**БАТЛАВ:**

**ЕИБҮТГАЗРЫН ДАРГА** **Т.АЛТАНХУЯГ**

# ЧУЛУУНЦРЫН ҮЙЛДВЭРИЙН ӨНДРИЙН БАРИЛГЫН ЗАСВАРЫН АЖЛЫН ДААЛГАВАР

Сэлэнгэ аймаг, Сайхан сум 2025 оны 05-р сарын 26

| № | Тодорхойлолт | Тайлбар |
|---|---|---|
| 1 | Үндэслэл | Чулуунцрын үйлдвэр нь 2013 оны 12 сард ашиглалтад орсон. С1-ийн гарах хийн хоолой, Бороожуулагчийн дээд оройн хэсгийн гадна дулаалгын хэсэг нь 2016 оноос хойш хүчтэй салхинд хуурч унасан. С1-ийн гарах халуун хийн температур 300-380$^0$С, Бороожуулагчийн гарах халуун хийн температур 290-350$^0$С байдаг бөгөөд дулаалгын хэсэг хуурсан нөхцөлд халуунаа алдах эрсдэлтэй тул технологийн горим зөрчигдөж байдаг |
| 2 | Захиалагч байгууллага нэр, хаяг | Монгол улс, Сэлэнгэ аймаг, Сайхан сум 1-р баг, Үйлдвэрийн район, “Цемент Шохой” ХХК |
| 4 | Захиалагчийн регистрийн дугаар: | 2641984 |
| 3 | Хийх ажил | Чулуунцрын үйлдвэрийн 110 метрийн өндөртэй 5-н үет дулаан солилцуулагчийн оройн хэсэг, Бороожуулагчийн хоолойн хэсэг, Тоос шүүх цахилгаан байгууламжийн гадна хэсэг нийт /1090.08м2/ |
| 4 | Зориулалт, хүчин чадал | Галыг дэмждэггүй материал ба галын аюултай бүсэд ашиглах зориулалтай |
| 5 | Хууль эрх зүй, дүрэм журам, барилгын норм ба дүрэм, стандарт | **<u>Хууль:</u>**<br>~ Барилгын тухай хууль;<br>~ Эрүүл ахуйн тухай хууль;<br>~ Галын аюулгүй байдлын тухай хууль;<br>~ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль;<br>~ Холбогдох хууль тогтоомжууд;<br>**<u>Барилгын норм ба дүрэм:</u>**<br>~ БНбД 52-02-05, БНбД 3.03.02-90;<br>~ БНбД 25-01-20 Барилгын дулаан хамгаалалт;<br>~ БНбД 31-16-11 Үйлдвэрийн газрын байгууламж;<br>~ БНбД 53-02-05, СНиП III-18-75 Ган бүтээц;<br>~ БНбД 23-05-10 Дуу чимээ тусгаарлалт;<br>~ БНбД 12-01-09 Барилгын ажлын талбайд барилгын үйлдвэрлэлийн зохион байгуулалт;<br>~ БНбД 12-03-04 Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм,<br>~ БД 12-101-05 Барилга угсралтын ажилд мөрдөх хөдөлмөр хамгааллын үлгэрчилсэн заавар; |

| | | |
|---|---|---|
| | | ~ БНбД 31-19-10 Агуулахын барилга;<br>~ БНбД 3.01.06-90<br>~ Орчны тохижилтын ажлыг зургийн дагуу;<br>~ Холбогдох бусад барилгын норм ба дүрэм;<br>**Стандарт:**<br>~ MNS EN 13162:2011 Барилгын дулаан тусгаарлах материал. Эрдэс хөвөн (MW) бүтээгдэхүүн Техникийн шаардлага;<br>~ MNS 4284:2006 - Галын аюулаас хамгаалах. Галын ангилал; - MNS 5215:2002 - Барилгын хашлага бүтээцийн хэлбэржүүлсэн гөлмөн төмөр. Техникийн шаардлага;<br>~ MNS 3178:1998 Эрдэс хөвөнгийн хавтан;<br>~ MNS 6227:2010 /Барилгын эрдэс хөвөн ба хөөсөн полистирол(PS) дулаалгатай олон үет төмөр хавтгайлж;<br>**Дүрэм журам:**<br>Барилга, инженерийн дэд бүтцийн захиалагчийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх журам;<br>*Үйлдвэрийн хөдөлмөр хамгааллын журам;*<br>Холбогдох дүрэм, журам, заавар; |
| 6 | Ажил гүйцэтгэх байгууллага | Холбогдох өндрийн тусгай зөвшөөрөлтэй, эрх бүхий байгууллага |
| 7 | Үндсэн ажил | ~ 5-н үет дулаан солилцуулагчийн оройн хоолойн хэсгүүдийн металл хийцийг зэврэлтийг арилган зориулалтын будгаар будах, чулуун хөвөн-100мм дулаалга, 0.6мм зузаан цайрдсан гөлмөн төмрөөр бүрэх, угсрах ажил /695м2/<br>~ Бороожуулагчийн хоолойн хэсгүүдийн металл хийцийг зэврэлтийг арилган зориулалтын будгаар будах, чулуун хөвөн-100мм дулаалга, 0.7мм зузаан шулуун хол алхамтай, өндөр хамартай, өнгөт төмрөөр бүрэх, угсрах ажил /326.08м2/<br>~ Тоос шүүх цахилгаан байгууламжийн барилгын гадна хэсэгт чулуун хөвөн-100мм дулаалга, цайрдсан гөлмөн төмрөөр угсрах ажил /69м2/ |
| | | Металл хоолойн дулаалга угсралтын ажлыг хийж гүйцэтгэхдээ зургийн шифр: КА-04/22 зураг төслийн дагуу, захиалагчийн шаардлагад нийцүүлэн ажиллах шаардлагатай. Батлагдсан зураг, төсвийн хоолойн хэсгүүдийн металл хийцийн угсралтын ажил хийж гүйцэтгэхдээ:<br>~ Угсралтын ажил гүйцэтгэх үе шатны график, буюу хугацаат ажлын график гаргах, |

| | | |
|---|---|---|
| 8 | Туслах ажил | ~ Талбайн зохион байгуулалтын зураглалыг ирүүлэх,<br>~ Байгалийн гэнэтийн гамшиг, гал түймэр, үер усны гамшгаас сэргийлэн даатгалд бүрэн хамрагдан аюулгүй байдлыг хангаж ажиллах,<br>~ Ажлын явцад болон ажил гүйцэтгэж дуусахад гарсан хог хаягдлыг хогийн цэгт хаях ажлыг бүрэн хариуцан талбайг цэвэрлэн хүлээлгэж өгөх,<br>~ Гүйцэтгэгч тал нь чанаргүй гүйцэтгэсэн ажлыг өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгөх<br>~ Оффис, амрах байрууд тус тусдаа төлөвлөгдсөн байх,<br>~ Барилга угсралтын ажил гүйцэтгэх явцад талбайд буй ажилчдад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч, холбогдох хууль тогтоомжийн дагуу ажиллах<br>~ *Шаардлагатай сургалтыг орох замаар*, чадавхжуулах. |
| * 9 | Төслийн үе шат, хугацаа | **Барилга угсралтын ажил 2 үе шаттай**<br>1. Батлагдсан зураг, төсвийн дагуу барилга угсралтын ажил, түүнтэй холбогдох барилга байгууламжийн угсралтын ажил гүйцэтгэх. Технологийн үе шат бүрд гүйцэтгэсэн ажлыг тогтмол хянуулах ба техникийн шаардлага хангасан гэж үзвэл зөвшөөрлийг авч ил, далд ажлын акт үйлдэж баталгаажуулан, материалын сертификат, /гүйцэтгэлийн зураг/ үйлдсэнээр дараагийн үе шатны ажлыг гүйцэтгэж байна.<br>2. Барилга угсралтын ажлын гүйцэтгэгч нь захиалагчтай байгуулсан гэрээний үүргээ биелүүлж, зохих хууль дүрэм журмын дагуу захиалагч талд хүлээлгэж өгнө. |
| 10 | Онцгой нөхцөл | ~ Захиалагчийн санаачилгаар зураг төсвийн ажилд өөрчлөлт орох тохиолдолд гүйцэтгэгч нь гарах зардлыг бүрэн хариуцна.<br>~ Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй барилгын норм дүрмийг баримтлан сүүлийн үеийн дэвшилтэт технологийн шийдлүүдийг сонгох.<br>~ Барилга угсралтын гүйцэтгэлийг захиалагч комисс хүлээж авах, гэрээ дүгнэх хүртэл хяналтын ажлыг захиалагч, гүйцэтгэгч тал *тогтмол хамтран хийж, үе шатны акт үйлдэж* баталгаажуулна |

| | | |
|---|---|---|
| 11 | Галын аюулгүй байдлын нөхцөл | Галын аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдох норм дүрмийн заалтуудыг мөрдлөг болгох. БНбД 21-05-04, БД 43-105-12, БНбД 21-01-02, БНбД 21-06-10, БНбД 2.09.12-87; |
| 12 | **Ажил гүйцэтгэх хугацаа:** | Барилга угсралтын ажлын гэрээ байгуулснаас хойш 1 сараар тооцно |
| 13 | Нийт төсөв | 500,000,000 төгрөг |

Хянасан:

Ерөнхий механик бөгөөд техникийн бодлогын хэлтсийн дарга Ц.Алтансүх

Чулуунцарын үйлдвэрийн дарга Н.Цэрэннадмид

Байгууллагын нөөц төдөвлөлт, эдийн засгийн хэлтсийн дарга Х.Батсүрэн

Боловсруулсан:

Барилгын инженер З.Батдэлгэр